



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2008 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 634

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 100,000,000.00 (нэг зуун сая) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Өмнөговь аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл, Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин, Өмнөговь аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга Г.Дуламцоо нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг бүртгэх ажлыг комисс томилон, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА



0002665

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
634 дугаар тогтоолын хавсралт



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хөрөнгийн үнэ (төгрөг)
1	Өмнөговь аймгийн Цогт-Овоо суман дахь Цаг уурын өртөөний барилга	2017	50,000,000.00
2	Өмнөговь аймгийн Манлай суман дахь Цаг уурын өртөөний барилга /50 м.кв/	2017	50,000,000.00
	Дүн	-	100,000,000.00 (нэг зуун сая)